



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/508

Мөрөн сум

Малын гоц халдварт шүлхий өвчний
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг ажлыг зохион байгуулах тухай” 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх үхэр, гахай, цаа бугыг хамруулан 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011121

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 03 өдрийн А/С-8
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

№	Аймаг	Сум	Олгох вакцин (мян/тун)	Хайрцаг (ширхэг)	Шил (ширхэг)
1	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	33.0	13	330
2		Арбулаг	34.6	13	346
3		Баянзүрх	36.4	14	364
4		Бүрэнтогтох	37.0	15	370
5		Галт	36.0	14	360
6		Жаргалант	34.5	13	345
7		Их-Уул	30.2	12	302
8		Мөрөн	14.5	6	145
9		Рашаант	24.8	10	248
10		Рэнчинлүмбэ	43.4	18	434
11		Тариалан	34.0	14	340
12		Тосонцэнгэл	29.7	12	297
13		Төмөрбулаг	29.2	12	292
14		Түнэл	40.7	16	407
15		Улаан-Уул	44.2	17	442
16		Ханх	29.0	11	290
17		Хатгал	20.2	8	202
18		Цагааннуур	11.2	4	112
19		Цагаан-Уул	42.2	16	422
20		Цагаан-Үүр	20.0	8	200
21		Цэцэрлэг	32.0	13	320
22		Чандмань-өндөр	28.0	11	280
23		Шинэ-Идэр	20.0	8	200
24		Эрдэнэбулган	29.0	11	290
25		Тавиул мал	20.7	9	207
		Дүн	754.5	269	7545

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 03 өдрийн А/506
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

ХЯНАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА,
МЭРГЭЖИЛТНИЙ ХУВААРЬ

№	Ажлын хэсэг	Ажиллах сум	Ажиллах байгууллага
1	1-р хэсэг	Төмөрбулаг	МЭГ ОБГ
2		Шинэ-идэр	
3		Галт	
4		Жаргалант	
5		Цэцэрлэг	
6		Цагаан-уул	
7		Бүрэнтогтох	
8	2-р хэсэг	Арбулаг	МЭГ ОБГ
9		Баянзүрх	
10		Улаан-уул	
11		Рэнчинлхүмбэ	
12		Цагааннуур	
13		Мөрөн	
14	3-р хэсэг	Алаг-эрдэнэ	МЭГ ОБГ
15		Чандмань-өндөр	
16		Цагаан-үүр	
17		Ханх	
18		Хатгал	
19	4-р хэсэг	Тосонцэнгэл	МЭГ ОБГ
20		Түнэл	
21		Их-уул	
22		Рашаант	
23		Тариалан	
24		Эрдэнэбулган	

_____оОо_____